



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/03

Баян-Овоо сум

**Хөдөлмөрийн дотоод журам
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.6, 43.1.7, 122 дугаар зүйлийн 122.1, 122.2, 122.3 дах заалт, хамт олны саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн хавсралтаар баталж, 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

2. Хөдөлмөрийн дотоод журмыг нийт багш, ажилтанд танилцуулж, мэдээллийн самбарт байршуулахыг сургалтын менежер (П.Болортуяа) нийгмийн ажилтан (А.Эрдэнэтуяа) нарт даалгасугай.

3. Хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, хэрэгжүүлэхийг нийт багш, ажилтанд үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталсан Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн хөдөлмөрийн дотоод журмыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч (Ж.Цагаачин)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ч.БОЛОРМАА